



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 64

Мандалговь

Хөрөнгө дансанд бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын "б" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2 нэр төрлийн 108,967.050 төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 7 нэр төрлийн 22,490.000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 9,336.000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, **нийт 140,793.050** төгрөг, ИТХ-ын 4,479.000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, Хот тохижуулах газрын 6 нэр төрлийн 10,170.000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн төвийн 13 нэр төрлийн 37,162,907.56 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 340,000 төгрөгийн тавилга, эд хогшил **нийт 37,502,907.56** төгрөг, Эрдмийн далай цогцолбор сургуулийн 11 нэр төрлийн 23,377.315 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 90 нэр төрлийн 4,740,275.1 төгрөгийн ном, сурах бичиг, **нийт 28,117,590.1** төгрөг, Хүмүүнлэг сургуулийн 31 нэр төрлийн 69,791,449 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 12,550.192 төгрөгийн тавилга, эд хогшил, **нийт 82,341.641** төгрөгийн, Цэгцбилиг сургуулийн 19 нэрийн 17,261.400 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8 нэр төрлийн 11,648.000 төгрөгийн тавилга, эд хогшил, 44 нэрийн 1,354,627.35 төгрөгийн ном, сурах бичиг, **нийт 30,264,027.35** төгрөгийн хөрөнгийг тус тус байгууллагын дансанд бүртгэх зөвшөөрөл олгосугай.

2. Орлогодох хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг журмын дагуу хангаж дансанд бүртгэхийг тус байгууллагуудын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг төсөвт байгууллагуудын дарга, захирал, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ